

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

*Орон нутгийн төсвийн орлого 108.6 хувиар биелж,
урсгал зардлыг 3,936.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.*

АГУУЛГА

Аудитын тайлан баталгаажуулсан тушаал	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Дүрслэлийн товъёг	4
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1.СУУРЬ ОРЛОГЫГ 5.1 ХУВИАР БУУРУУЛЖ, ЗАРЛАГЫГ 4.4 ХУВИАР НЭМЖ ТОДОТГОСОН БАЙНА.....	7
А.1. Төсвийн орлогын төлөвлөгөөг төсвийн жилийн дундуур 1,429.0 сая төгрөгөөр бууруулан баталжээ.....	7
А.1.1 УИХ-аар хянагдаж ирсэн төсвийн суурь орлогыг 4,393.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.....	7
А.1.2 Төсөвт зохицуулалт хийхдээ суурь орлогыг 45.9 сая төгрөгөөр бууруулжээ.	8
А.2. Төсөвт зохицуулалт хийхдээ урсгал зардлыг 50.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.....	9
А.2.1. Төсвийн санал боловсруулахдаа Сангийн яамны урьдчилан тооцсон төсвийн хязгаараас 8,412.7 сая төгрөгөөр өндөр төсөвлөжээ.....	9
А.2.2. Хуульд заасны дагуу төсөвт тодотгол хийсэн хэдий ч төсвийн зохицуулалт хийхдээ урсгал зардлыг 50.0 сая төгрөгөөр бууруулж баталжээ.	10
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО 108.6 ХУВИАР БИЕЛСЭН БАЙНА.....	12
Б.1 Төсвийн орлого нийт дүнгээр биелсэн ч Хонгор сумын орлого 27.6 хувиар тасарсан байна.....	12
Б.1.1 Аймаг, сумдын орлогын төлөвлөгөө 2,267.4 сая төгрөгөөр давж биелжээ.....	12
Б.1.2 Хонгор сумын суурь орлогын төлөвлөгөө 27.6 хувиар тасарсан байна.....	12
Б.2. Төсвийн орлого 8.6 хувиар давсан боловч зарим нэр төрлийн орлого тасарчээ.....	13
Б.2.1 Орон нутгийн төсвийн орлого 108.6 хувиар биелсэн байна.	13
Б.2.2 Ковид-19 цар тахлын улмаас аймаг, сумдын зарим орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлжээ.	14
БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	15
В.1. Урсгал зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй зарцуулжээ.....	15
В.1.1. Цалин, нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгох зөрчил нийтлэг байна.	15
В.1.2 Орон нутгийн төсвийн байгууллагууд урсгал зардлыг 12.6 хувиар буюу 2,766.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.	16
В.2. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 88.2 хувьтай биелжээ.....	16
В.2.1. Хөрөнгө оруулалтыг 149.0 сая төгрөгөөр хэмнэсэн байна.	16
В.2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийсэн байна.....	17
Холбогдох байгууллагаас ирсэн санал:	18
Тайланд тусгасан тэмдэглэл:	20
ДҮГНЭЛТ:.....	21
ЗӨВЛӨМЖ:.....	21
Зөрчлийн нэгтгэл:	Error! Bookmark not defined.
Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн судалгаа:	Error! Bookmark not defined.

Аудитын тайлан баталгаажуулсан тушаал



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 дугаар сарын 20 өдөр

№ А/05

Дархан-Уул аймаг

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх"-ийн 2.4, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу "Дархан-Уул аймгийн 2020 оны орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Засаг дарга Б.Азжаргал, Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа, Орхон сумын Засаг дарга Б.Алтансарнай, Хонгор сумын Засаг дарга Т.Атархишиг, Шарын гол сумын Засаг дарга Б.Лхамсүрэн нарт тус тус хүргүүлж, тайланд дурдагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 11 дугаар сарын 30-ний дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг зөвлөсүгэй.

3. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /У.Батсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР

D:\Backup\bichig heregl\TUSHAAL.docx

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НААҮГ	Нийтийн аж ахуй үйлчилгээний газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СХС	Сум хөгжүүлэх сан
ХО	Хөрөнгө оруулалт
УТ	Улсын төсөв
НААҮГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ААН	Аж ахуйн нэгж
ДДЦС	Дулааны цахилгаан станц
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХК	Хувьцаат компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Орон нутгийн 2020 оны төсвийн орлогын төсвийн төсөл, батлагдсан төсөв	6
Хүснэгт №2	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний өөрчлөлт	7
Хүснэгт №3	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний өөрчлөлтүүд	8
Хүснэгт №4	ИТХ-ын тодотгол	9
Хүснэгт №5	Төсвийн зохицуулалт	10
Хүснэгт №6	Орон нутгийн 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого	11
Хүснэгт №7	Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл	11
Хүснэгт №8	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Хүснэгт №9	Тасарсан орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	13
Хүснэгт №10	Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл	14
Хүснэгт №11	Урсгал зардлын гүйцэтгэл	15
Хүснэгт №12	Хөрөнгийн зардлын гүйцэтгэл	16

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Суурь зарлагын төлөвлөлт	8
Дүрслэл №2	Баталсан нийт зарлагын төсөв	10

**Аудит хийх
үндэслэл, бүрэн эрх****Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн
талаарх мэдэгдэл**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 2021 оны А/28 дугаар тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 -т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Дархан-Уул аймгийн 2020 оны нэгдсэн төсвийн зарлага үр дүнтэй зарцуулагдсан эсэхийг шалгаж, дүгнэлт гарган, аймгийн удирдлагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- Төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх;

**Аудитын хамарсан
хүрээ**

Аудитыг Дархан-Уул аймгийн орон нутгийн төсөв, ТЕЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020 оны санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

**Аудитын
хязгаарлалт****Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-300, 3000-3100-г үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах шалгагдагч байгууллагаас авсан бүх төрлийн нотлох зүйлсийг нягтлан шалгаж, нөхцөл байдлын шинжилгээ хийж, аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэлтсийн дарга, аудитын менежер Ш.Мөнхбаяр хэрэгжүүлж, аудитор У.Батсүрэн, Н.Отгонцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Ерөнхий мэдээлэл

Дархан-Уул аймгийн 2020 оны төсвийн орлого татварын ба татварын бус орлого, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдсэн бөгөөд эх үүсвэрийг орон нутгийн төсвийн 25, тусгай зориулалтын 77 байгууллага, орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, замын сан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ зэрэг зардлыг санхүүжүүлэхээр нийт 78,232.0 сая төгрөгийн орлого төлөвлөж, гүйцэтгэлээр 72,685.3 сая төгрөг зарцуулжээ.

Аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагыг аймгийн ИТХ-ын 2019 оны 15/07 дугаар тогтоолоор 79,467.0 сая төгрөг баталж, төсвийн тодотголоор 1,189.1 сая, төсвийн зохицуулалтаар 45.9 сая төгрөг тус тус бууруулж өөрчлөн баталсан бөгөөд төсвийн нийт орлогын гүйцэтгэл 98.7 хувиар, зарлагын гүйцэтгэл 92.9 хувьтай гарсан байна.



БҮЛЭГ 1. СУУРЬ ОРЛОГЫГ 5.1 ХУВИАР БУУРУУЛЖ, ЗАРЛАГЫГ 4.4 ХУВИАР НЭМЖ ТОДОТГОСОН БАЙНА.

А.1. Төсвийн орлогын төлөвлөгөөг төсвийн жилийн дундуур 1,429.0 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

А.1.1 УИХ-аар хянагдаж ирсэн төсвийн суурь орлогыг 4,393.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлийн 58.2-д заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн аймгийн 2020 оны төсвийн орлогыг боловсруулжээ.

Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжид Дархан-Уул аймгийн суурь орлогыг 25,808.2 сая төгрөгөөр төсвийн хязгаарыг тооцсон байна. Харин Дархан-Уул аймгийн ТЕЗ нь суурь орлогыг 21,084.7 сая төгрөг буюу 4,723.5 сая төгрөгөөр төсвийн төслийг бууруулан боловсруулжээ.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны шийдвэрээр Дархан-Уул аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 23,467.9 сая, үүнээс татварын орлогыг 22,082.9 сая, татварын бус орлогыг 1,385.0 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №1

Орон нутгийн 2020 оны төсвийн орлогын төсвийн төсөл, батлагдсан төсөв /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төсвийн төсөл	УИХ-ын баталсан төсөв /2019.11.13/	ИТХ-ын баталсан төсөв /2019.12.02/	Зөрүү	
					Төсвийн төслөөс	УИХ-аас
	Орон нутгийн төсвийн суурь орлого	21,084.8	23,467.9	27,861.0	6,776.2	4,393.1
1	Татварын орлого	20,062.8	22,082.9	24,946.3	4,883.5	2,863.4
1.1	ХХОАТатвар	19,437.7	20,273.0	21,178.0	1,740.3	905.0
1.2	ХХХОАТ-ын буцаалт	(3,200.0)	(2,500.0)	(2,052.0)	1,148.0	448.0
1.3	Хөрөнгийн албан татвар	1,599.7	1,784.9	2,122.0	522.3	337.1
1.4	Бусад татвар /төлбөр хураамж/	2,225.4	2,525.0	3,698.3	1,472.9	1,173.3
2	Татварын бус орлого	1,022.0	1,385.0	2,914.7	1,892.7	1,529.7
2.1	Хүү, торгуулийн орлого	1,022.0	1,100.0	1,504.0	482.0	404.0
2.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	175.0	278.2	278.2	103.2
2.3	Бусад орлого	-	110.0	375.0	375.0	265.0
2.4	Сум хөгжүүлэх сангийн орлого	-	-	757.5	757.5	757.5

Аймгийн ИТХ-ын 2019 оны 15/07 дугаар тогтоолоор аймгийн төсвийн суурь орлогыг төсвийн төслөөс 6,776.2 сая, УИХ-аас хянаж ирүүлсэн суурь орлогоос 4,393.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан нь өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлд тулгуурласан байна.

Мөн ТЗШ-ийн орлогоос 42,784.2 сая, ЭМД-ын сангаас 181.0 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 6,534.4 сая, ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлогоос

154.3 сая, нийт 49,653.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, улсын төсөвт 1,898.8 сая төгрөг төвлөрүүлэхээр баталжээ.

А.1.2 Төсөвт зохицуулалт хийхдээ суурь орлогыг 45.9 сая төгрөгөөр бууруулжээ.

Төсвийн жилийн дундуур Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дүгээр сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Дархан-Уул аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 22,707.9 сая, үүнээс татварын орлогыг 21,182.9 сая, татварын бус орлогыг 1,525.0 сая төгрөгөөр баталж, өмнөх шийдвэрээс 760.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Хүснэгт №2

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний өөрчлөлт /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ИТХ-ын анх баталсан төсөв /2019.12.02/	УИХ-ын тодотгосон төсөв	ИТХ-ын тодотгосон төсөв /2020.09.18/	Зөрүү	
					Анх баталсан төсвөөс	УИХ-аас
	Орон нутгийн төсвийн суурь орлого	27,861.0	22,707.9	26,478.2	(1,382.8)	3,770.3
1	Татварын орлого	24,946.3	21,182.9	23,319.5	(1,626.8)	2,136.6
1.1	ХХОАТатвар	21,178.0	19,498.0	19,308.1	(1,869.9)	(189.9)
1.2	ХХХОАТ-ын буцаалт	(2,052.0)	(2,500.0)	(1,583.5)	468.5	916.5
1.3	Хөрөнгийн албан татвар	2,122.0	1,784.9	2,165.0	43.0	380.1
1.4	Бусад татвар /төлбөр хураамж/	3,698.3	2,400.0	3,429.9	(268.4)	1,029.9
2	Татварын бус орлого	2,914.7	1,525.0	3,158.7	244.0	1,633.7
2.1	Хүү, торгуулийн орлого	1,504.0	1,100.0	1,906.3	402.3	806.3
2.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	278.2	175.0	202.2	(76.0)	27.2
2.3	Бусад орлого	375.0	250.0	265.7	(109.3)	15.7
2.4	Сум хөгжүүлэх сангийн орлого	757.5	-	784.5	27.0	784.5

Аймгийн ИТХ-ын 2020 оны 18/01 дүгээр тогтоолоор суурь орлогыг анх баталсан төсвөөс 1,382.8 сая төгрөгөөр бууруулсан бол УИХ-ын тодотгон баталсан суурь орлогыг 3,770.3 сая төгрөгөөр нэмж тодотгожээ.

ХХОАТ-ын орлогыг 1,869.9 сая төгрөгөөр бууруулсан нь УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой байна. Үүнд:

- Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин хөлсний орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх,
- Татвар төлөгчид хуулийн дагуу ногдуулсан төлбөл зохих татварыг тодорхой хугацаанд төлөөгүй тохиолдолд алданги, торгуулиас нэг удаа чөлөөлөх зэрэг арга хэмжээний хүрээнд ХХОАТ-ыг бууруулан тодотгожээ.

Гэсэн хэдий ч Хонгор сум нь тооцоо, судалгаагүйгээр татварын бус орлогыг 155.8 сая төгрөгөөр нэмж тодотгосноор төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдаж, өр төлбөр үүсэх эрсдэл бий болсон байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 27 дугаар зүйлийн 27.1.2-т “макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний өөрчлөлтүүд /сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар		
	2019.12.02 №15/07	2020.09.18 №18/01	2020.12.04 2/01
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	79,467.0	78,270.5	78,232.0
УРСГАЛ ОРЛОГО	27,861.0	26,478.2	26,432.3
Татварын орлого	24,946.3	23,319.5	23,279.5
Татварын бус орлого	2,914.7	3,158.7	3,152.8
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	51,606.0	51,792.3	51,799.7

МУЗГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 187 тоот тогтоолоор “Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай” шийдвэрээр орон нутгийн төсвийн суурь орлогыг нийт 45.9 сая төгрөгөөр бууруулжээ. Энэ нь Дархан сум ИТХ-ын 2020 оны 09 дүгээр тогтоолоор орлогыг 50.0 сая төгрөгөөр бууруулж, Хонгор сум ИТХ-ын 2020 оны 10 дугаар тогтоолоор 4.1 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

А.2. Төсөвт зохицуулалт хийхдээ урсгал зардлыг 50.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

А.2.1. Төсвийн санал боловсруулахдаа Сангийн яамны урьдчилан тооцсон төсвийн хязгаараас 8,412.7 сая төгрөгөөр өндөр төсөвлөжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор орон нутгийн төсвийн саналаа Сангийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 4-1/4669 дугаар албан бичгээр ирүүлсэн төсвийн удирдамжийн урьдчилан тооцсон суурь зарлагаас 8,412.7 сая, 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 6,396.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 24,521.5 сая төгрөгөөр төсөвлөжээ.

Дүрслэл №1

Суурь зарлагын төлөвлөлт /сая төгрөгөөр/

Хүлээгдэж буй гүйцэтгэлээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,811.4 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 906.3 сая, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 842.2 сая төгрөгөөр тус тус нэмж төсөвлөсөн нь 2020 онд баримтлах төсвийн бодлого, зарчимтай уялдаагүй байна. Мөн

Сангийн яамнаас дээрх зардлыг 22.3-73.5 хувиар бууруулж хянасан нь төсөв хэт өндөр дүнгээр төлөвлөгдсөнийг харуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Дархан-Уул аймгийн төсвийн суурь зарлагыг 18,163.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс 1,025.1 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжүүлж, төсвийн тэнцэл 6,329.5 сая төгрөгөөс 1,898.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 42,976.5 сая, ОНХС-ийн орлогын шилжүүлгээр 6,594.3 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр хянаж баталжээ.

ТЕЗ орлогын эх үүсвэрт тулгуурлан аймгийн төсвийн суурь зарлагыг 2,323.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 20,486.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлого 154.4 сая, ОНХС-ийн шилжих хөрөнгө оруулалт 522.8 сая, сум хөгжүүлэх сангийн орлогыг 757.7 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 7,100.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн нийт 79,467.0 сая төгрөгийн зарлага баталсан байна.

Сангийн яамны хянасан суурь зарлагыг нэмэгдүүлэхэд дараах зардлууд нөлөөлжээ. Үүнд:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8, 14, 18, 19 дүгээр зүйлд заасныг үндэслэн улс төрийн намуудад олгох санхүүгийн дэмжлэгт 270.8 сая, цалин, НДШ, зочин төлөөлөгч хүлээн авах, иргэний зөвлөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлуудыг нэмснээр сумдын ИТХ-ын зардлыг 208.3 сая төгрөгөөр,
- Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58 дугаар зүйлийн 58.4.1-д заасан орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой аймаг, сумдын ЗДТГ-ын зардлыг нийт 1,111.5 сая төгрөгөөр,
- Хуульд заасан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу махны нөөц бэлтгэх зардлыг шилжих үлдэгдэл 210.6 сая, Мэдээлэл технологийн алба, Аж үйлдвэрийн паркийн санхүүгийн дэмжлэгийг 128.5 сая хүүхдийн автобус үйлчилгээний 75.0 сая төгрөгөөр
- Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4.8 дахь заалт, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, гудамжны гэрэлтүүлэг нэмэгдсэнтэй холбоотойгоор НААҮГ-ын урсгал зардлыг 342.3 сая төгрөгөөр аймаг, сумдын ИТХ-аар тус тус нэмж баталжээ.

А.2.2. Хуульд заасны дагуу төсөвт тодотгол хийсэн хэдий ч төсвийн зохицуулалт хийхдээ урсгал зардлыг 50.0 сая төгрөгөөр бууруулж баталжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Дархан-Уул аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг 510.7 сая, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 74.8 сая, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 170.6 сая, ТЗШ-ийн байгууллагуудын урсгал зардлыг 1,005.0 сая, нийт 1,761.1 сая төгрөгөөр бууруулж, 66,846.9 сая төгрөгөөр хянасан байна.

Хүснэгт №4


ИТХ-ын тодотгол /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Анх баталсан	Тодотгол	Зөрүү
Суурь зарлага	20,486.7	21,397.1	910.4
ТЗШ	43,130.9	42,084.1	(1,046.8)
ОНХС	6,092.0	5,921.4	(170.6)
ХО	7,100.9	6,114.0	(986.9)
СХС	757.6	937.1	179.5
УТ-т төвлөрүүлэх	1,898.8	1,824.1	(74.7)
НИЙТ ЗАРЛАГА	79,466.9	78,277.8	(1,189.1)

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-д заасны дагуу аймаг, сумдын ИТХ-аар орон нутгийн төсвийн суурь зарлагыг 21,397.1 сая төгрөгөөр баталж, Сангийн яамны хянасан дүнгээс 3,744.3 сая төгрөгөөр нэмсэн байна. Мөн ТЗШ-ийг төсөвт байгууллагуудын өөрийн орлого 112.6

сая, ОНХС-ийн шилжих хөрөнгө оруулалт 522.8 сая, сум хөгжүүлэх сангийн 937.1 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 6,114.1 сая, нийт 78,277.9 сая төгрөгийн зарлага баталсан нь өмнөх төсвөөс 1,189.1 мянган төгрөгөөр буурчээ.

Дүрслэл №2

Баталсан нийт зарлагын төсөв /хувиар/

Суурь зарлагыг 910.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь өвс тэжээл, махны нөөц бүрдүүлэхэд 476.7 сая, аймаг, сумдын ЗДТГ-т нөөц хөрөнгөд 152.5 сая, Хонгор сумын хөрөнгийн зардалд 100.0 сая, урсгал зардалд 202.7 сая, Дархан орон нутгийн зам тээврийн газарт санхүүгийн дэмжлэг 92.9 сая,

НААҮГ-ын гэрэлтүүлэгт 136.8 сая, тэтгэвэр тэтгэмжийн зардалд 50.0 сая төгрөг тус тус нэмж баталсантай холбоотой.

Төсвийн тодотголоор урсгал зардлыг 1.6 хувиар буюу 1,040.1 сая, хөрөнгийн зардлыг 8 хувиар буюу 1,057.5 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 187 дугаар тогтоолоор баталсан ТЕЗ нарт зохицуулалт хийх эрх олгосны дагуу аймгийн ИТХ-ын 2020 оны 2/01 тогтоолоор 388.2 сая төгрөгийн хэмнэлтийг КОВИД-19 цар тахалтай тэмцэх арга хэмжээнд зарцуулахаар баталжээ.

ТЕЗ төсөвт зохицуулалт хийхдээ хэмнэгдсэн зардлыг аймгийн Засаг даргын нөөц санд шилжүүлсэн хэдий ч НААҮГ-ын хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэгээ үйлчилгээний хөтөлбөр арга хэмжээний 50.0 сая төгрөгийн зардлыг бууруулж баталсан нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Хүснэгт №5

Төсвийн зохицуулалт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төсвийн тодотгол	Төсвийн зохицуулалт	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	78,277.9	78,232.0	(45.9)
Урсгал зардал	65,193.9	65,148.4	(45.5)
Бараа, ажил үйлчилгээний зардал	57,446.4	57,505.4	59.0
Татаас	4,088.2	4,088.2	-
Урсгал шилжүүлэг	3,659.3	3,554.7	(104.5)
Хөрөнгийн зардал	12,175.5	12,175.5	-
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	908.5	908.2	(0.3)

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО 108.6 ХУВИАР БИЕЛСЭН БАЙНА.**Б.1 Төсвийн орлого нийт дүнгээр биелсэн ч Хонгор сумын орлого 27.6 хувиар тасарсан байна.****Б.1.1 Аймаг, сумдын орлогын төлөвлөгөө 2,267.4 сая төгрөгөөр давж биелжээ.**

Нийт орлогын гүйцэтгэл өнгөрсөн оноос 10,633.4 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон тусгай зориулалтын болон ОНХНС-ийн шилжүүлгийн орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нэгдсэн төсвийн суурь орлого 28,699.7 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 2,267.4 сая төгрөгөөр давж, анх баталсан төсвөөс 838.7 сая төгрөгөөр давсан байна. Үүнээс үзэхэд төсвийн тодотголоор орон нутгийн төсвийн орлогыг бууруулах шаардлагагүй байжээ.

Хүснэгт №6

Орон нутгийн 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2020 оны			Зөрүү	
	Анх баталсан төсөв	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Анх баталсан төсвөөс	Тодотгосон төсвөөс
Нийт орлого ба тусламжийн дүн	79,467.0	78,232.0	77,197.7	(2,269.3)	(1,034.3)
Татварын орлого	24,946.3	23,279.5	25,316.3	370.0	2,036.8
Татварын бус орлого	2,914.7	3,152.8	3,383.4	468.7	230.6
Тусламжийн орлого	51,606.0	51,799.7	48,498.0	(3,108.0)	(3,301.7)

Төсвийн суурь орлого нийт дүнгээр 108.6 хувиар биелсэн нь цалин, хөлсний албан татварын орлого 1,397.7 сая, бусад орлого 606.9 сая, үл хөдлөх хөрөнгийн татварын орлого 275.8 сая төгрөгөөр тус тус давж биелснээс шалтгаалжээ.

Б.1.2 Хонгор сумын суурь орлогын төлөвлөгөө 27.6 хувиар тасарсан байна.

Аймгийн төсвийн орлого гүйцэтгэлээр 2,030.4 сая төгрөгөөр буюу 10.6 хувиар, сумдын төсвийн орлого нийт 237.0 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар давж биелжээ.

Хүснэгт №7

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Аймаг	19,162.2	21,192.6	2,030.4	110.6
Татварын орлого	17,247.7	18,889.8	1,642.1	109.5
Татварын бус орлого	1,914.5	2,302.8	388.3	120.3
Дархан сум	5,855.7	6,229.2	373.5	106.4
Татварын орлого	5,216.1	5,577.9	361.8	106.9
Татварын бус орлого	639.6	651.3	11.7	101.8
Шарын гол сум	412.5	486.1	73.6	117.8
Татварын орлого	276.1	340.7	64.4	123.4
Татварын бус орлого	136.4	145.4	9.0	106.6
Хонгор сум	832.5	602.9	(229.6)	72.4
Татварын орлого	446.7	402.6	(44.1)	90.1
Татварын бус орлого	385.8	200.3	(185.5)	51.9
Орхон сум	169.4	188.9	19.5	115.7
Татварын орлого	92.8	105.3	12.5	113.6
Татварын бус орлого	76.6	83.6	7.0	109.1

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2,267.4 сая төгрөгөөр давж биелсэн ч, Хонгор сум 229.6 сая төгрөгөөр буюу 27.6 хувиар орлогын гүйцэтгэл тасарчээ. Үүнд газрын төлбөрийн орлого 77.5 сая, хүү торгуулийн орлого 153.8 сая төгрөгөөр тус тус тасарсан нь сумын суурь орлого тасрахад нөлөөлсөн байна.

Мөн Хонгор сумын татварын бус орлого өмнөх онд 32.7 хувиар, тайлант онд 48.1 хувиар тус тус тасарсан нь төсвийн жилийн дундуур тооцоо, судалгаагүйгээр татварын бус орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлснээс 213.5 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2¹-т заасантай нийцэхгүй байна.

Б.2. Төсвийн орлого 8.6 хувиар давсан боловч зарим нэр төрлийн орлого тасарчээ.

Б.2.1 Орон нутгийн төсвийн орлого 108.6 хувиар биелсэн байна.

Орон нутгийн төсвийн орлого 28,699.7 сая төгрөгт хүрч гүйцэтгэл 108.6 хувиар биелснээс татварын орлого 2,036.8 сая, татварын бус орлого 230.6 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Хүснэгт №8

Аймгийн нийт орлогын гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	2020 он			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	23,279.5	25,316.3	2,036.8	108.7
Татварын бус орлого	3,152.8	3,383.4	230.6	107.3
ОНХС-ийн орлогын шилжүүлэг	6,423.7	6,380.9	(42.8)	99.3
Тусгай зориулалтын шилжүүлэг	41,790.6	41,790.6	0.0	100.0
НДС-гийн төсвөөс санхүүжих	181.0	164.8	(16.2)	91.0
ТЗШ-ийн байг-ын өөрийн орлого	112.6	9.2	(103.4)	8.2
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,291.8	152.5	(3,139.3)	4.6
ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	78,232.0	77,197.7	(1,034.3)	98.7

Дээрх хүснэгтээс давсан орлогын шалтгааныг авч үзвэл:

- **Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого:** Төсвийн жилийн дундуур коронавируст цар тахалтай холбоотойгоор аймгийн ИТХ-аар тус орлогыг бууруулан баталжээ. Харин НДХ-ийн шимтгэл төлөгч болон Татварын албаны татвар төлөгчдийн тоон мэдээллийг тулган тандалт хийснээр татвар төлөгчдийн тайлагналыг баталгаажуулж татвар төлөхөөс зайлсхийхээс сэргийлэх арга хэмжээ авснаар тус орлого 1,397.7 сая төгрөгөөр,
- **Бусад орлого:** “Эрдэнэс-таван толгой” ХК-ий хувьцааны ногдол ашгийн татвар тайлант оны эцэст орж ирснээс 606.8 сая төгрөгөөр,
- **Үл хөдлөх хөрөнгийн татварын орлого:** УБХ-тэй үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг тулган баталгаажуулж хамтран ажилласны үр дүнд 275.8 сая төгрөгөөр,
- **Хүү, торгуулийн орлого:** Хууль хяналтын байгууллагууд болон замын цагдаагийн ажлын хүрээнд хийгдсэн хүү, торгууль, актын барагдуулалтыг эрчимжүүлснээр 79.5 сая төгрөгөөр,
- **Бусад нэр заагдаагүй орлого:** Тайлант онд орон нутгийн өмч түрээслүүлсний орлого болон орон нутгийн өмчид бүртгэлтэй орон сууц дуудлага худалдаагаар борлуулсны орлого 94.2 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

¹ жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх

Б.2.2 Ковид-19 цар тахлын улмаас аймаг, сумдын зарим орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлжээ.

Татварын орлого нийт дүнгээр 108.6 хувь биелсэн боловч 4 төрлийн орлого 293.4 сая төгрөгөөр тасарсныг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9

Тасарсан орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	
		Төлөв	Гүйц	2019 оны гүйц-ээс	Төлөв-өөс
Улсын тэмдэгтийн хураамж	468.0	462.7	364.7	(103.3)	(98.0)
Газрын төлбөр	1,061.2	1,296.6	1,236.5	175.3	(60.1)
Газрын дуудлага худалдааны орлого	278.7	200.0	139.0	(139.7)	(61.0)
Ус рашаан нөөц ашигласны төлбөр	650.0	622.5	548.2	(101.8)	(74.3)

Эдгээр татварын орлого тасрахад дараах шалтгаан нөлөөлсөн байна. Үүнд:

- **Улсын тэмдэгтийн хураамж:** Төрийн байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарласнаас орлого 98.0 сая төгрөгөөр,
- **Газрын төлбөр:** Газрын төлбөрийн барагдуулалтад анхаарч ажиллаагүйгээс Хонгор сумын орлого 64.9 сая, Дархан сумын орлого 158.2 сая төгрөгөөр дутуу биелж, нийт гүйцэтгэл 60.1 сая төгрөгөөр,
- **Газрын дуудлага худалдааны орлого:** 11 нэгж талбарт газрын дуудлага худалдааг 3 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүйгээс дуудлага худалдаа амжилтгүй болж орлого 61.0 сая төгрөгөөр,
- **Ус рашаан нөөц ашигласны төлбөр:** Цар тахлын улмаас ААН, төрийн байгууллагын үйл ажиллагааг хязгаарласан, “ДДЦС” ТӨХК-д техникийн саатал, эвдрэл гарснаас усны хэрэглээ буурсан зэрэг шалтгаанаар орлого 74.3 сая төгрөгөөр тус тус тасарчээ.

БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

В.1. Урсгал зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй зарцуулжээ.

В.1.1. Цалин, нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгох зөрчил нийтлэг байна.

Аймгийн орон нутгийн 2020 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд 78,232.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 72,685.3 сая төгрөг зарцуулж, зардлын гүйцэтгэл 92.9 хувьтай гарсан нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 6,857.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №10

Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	
		Төлөв	Гүйц	2019 оны гүйц-ээс	Төлөв-өөс
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	65,828.2	78,232.0	72,685.3	6,857.1	(5,546.7)
Урсгал зардал	54,911.8	65,148.4	61,212.2	6,300.4	(3,936.2)
Хөрөнгийн зардал	10,074.4	12,175.5	10,742.7	668.3	(1,432.8)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	842.0	908.2	730.4	(111.6)	(177.8)

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн урсгал зардал 61,212.2 сая төгрөг буюу 94.0 хувийн гүйцэтгэлтэй гарч өнгөрсөн оноос 6,300.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 10,742.7 сая төгрөг буюу 88.2 хувийн гүйцэтгэлтэй гарч өнгөрсөн оноос 668.3 сая төгрөгөөр өсжээ. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 730.4 сая төгрөг буюу 80.4 хувийн гүйцэтгэлтэй гарч өнгөрсөн оноос 111.6 сая төгрөгөөр буурахад СХС-ийн зээлийн шалгуур хангах оролцогч ирээгүйгээс Дархан суманд 75.4 сая төгрөг зарцуулаагүй үлдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой нийт 401.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 19.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 128.7 сая төгрөгийн албан шаардлага, 126.6 сая төгрөгийн зөвлөмж өгч, 126.8 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

Төлбөрийн акт тогтоосон зөрчлийн 93 хувь нь холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс цалин, нэмэгдэл хөлсийг илүү буюу давхардуулан олгосон зөрчил байгаа бол албан шаардлагын 91 хувь нь цалингийн сүлжээ, зэрэг дэвийн нэмэгдлийг буруу тогтоосон, батлагдаагүй орон тоонд хавсран ажиллуулсан зэрэг зөрчил эзэлж байна.

Мөн сум хөгжүүлэх сангийн 51.0 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, төсвийн зохистой удирдаагүйгээс 31.9 сая төгрөгийн өр төлбөр үүссэн, 21.7 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар гүйлгээ хийсэн, 7.1 сая төгрөгийн цалин, нэмэгдэл хөлсийг зөрүүтэй тооцсон зэрэг зөрчил байгууллагуудад нийтлэг илэрчээ.

Дээрх нийт алдаа зөрчлийн 36.3 хувийг орон нутгийн төсвийн, 63.8 хувийг ТЗШ-ийн байгууллагуудын алдаа зөрчил эзэлж байгаа бөгөөд цалин, нэмэгдэл хөлсийг зөрүүтэй тооцож олгосон 142.6 сая төгрөгийн зөрчил 38 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланд гарсан байна.

В.1.2 Орон нутгийн төсвийн байгууллагууд урсгал зардлыг 12.6 хувиар буюу 2,766.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Нийт урсгал зардлын гүйцэтгэлд ТШЗ-ийн байгууллагын зардал 68.2 хувийг эзэлж байгаа бөгөөд зардлын гүйцэтгэл 97.3 хувьтай гарсан бол орон нутгийн төсөвт байгууллагуудын зардал 31.2 хувийг эзэлж, зардлын гүйцэтгэл 87.4 хувьтай гарсан байна.

Хүснэгт №11

Урсгал зардлын гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2020 он		Зөрүү
	Төлөв	Гүйц	
Урсгал зардал	65,148.4	61,212.2	(3,936.2)
БАҮ-ний зардал	57,505.6	54,664.0	(2,841.6)
Татаас	4,088.2	3,235.6	(852.6)
Урсгал шилжүүлэг	3,554.7	3,312.6	(242.1)

Урсгал зардлын гүйцэтгэл 94.0 хувьтай гарч 3,936.2 сая төгрөг хэмнэгдсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор хэмнэлтийн горимд шилжүүлж, цалин, тэтгэвэр,

тэтгэмжээс бусад зардлыг тэвчих, (Ковид-19) халдварын цар тахлын улмаас зарим байгууллагын үйл ажиллагааг зогсоосон зэргээс шалтгаалсан байна. Тухайлбал:

- Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагааг зогсоосноор нормативт зардал 1,061.8 сая төгрөгөөр,
- Оны эцэст төсөв захирагч нарын хэмнэгдсэн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөд нэмж баталснаар бараа, үйлчилгээний бусад зардал 679.7 сая төгрөгөөр,
- Засаг даргын ерөнхий данснаас махны нөөц бэлтгэх зардлыг 400.0 сая төгрөгөөр тодотгосон, сургуулийн хүүхдийн автобус, нийтийн тээвэрт олгох татаас 353.6 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжсэн нь урсгал зардлын гүйцэтгэл буурахад нөлөөлжээ.

Орон нутгийн төсвийн давсан орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх 1,824.1 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлж, мөн оны эцэст ТЗШ-ийн байгууллагуудын зарцуулаагүй үлдэгдэл 1,633.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

ТШЗ-ийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд нийт 3,698.1 сая төгрөг төвлөрснөөс гүйцэтгэлээр 3,490.4 сая төгрөгийг урсгал зардалд, 207.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулжээ. Зарлагын гүйцэтгэлийн 22.1 хувийг ТЗШ-ийн байгууллагууд, 77.9 хувийг орон нутгийн төсвийн байгууллагын зарлага эзэлж байна. Нэмэлт санхүүжилтийг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмын хүрээнд зарцуулсан байна..

В.2. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 88.2 хувьтай биелжээ.

В.2.1. Хөрөнгө оруулалтыг 149.0 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 218 төсөл арга хэмжээнд 6,114.0 сая төгрөг баталж, гүйцэтгэл 90 хувьтай, ОНХС-ийн хөрөнгөөр 110 төсөл арга хэмжээнд 5,921.4 сая төгрөг баталж, гүйцэтгэл 87.9 хувьтай байна.

Хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөгөөнөөс 608.4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн нь гүйцэтгэгч байгууллагад олгох баталгаат хугацааны барьцаа 28.7 сая төгрөг, он дамжин хэрэгжиж байгаа 6 төсөл арга хэмжээний 341.9 сая төгрөг, огт хэрэгжээгүй 7 ажлын 103.6 сая төгрөг, тендерийн хэмнэлт 80.3 сая төгрөг, ажлын

гүйцэтгэл болон бичиг баримт хангалтгүй, техник хяналтын зардал, зургийн үнэ, комисс хүлээн аваагүй шалтгаанаар 53.9 сая төгрөг тус тус үлджээ.

Огт хэрэгжээгүй нийт 103.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээний 33.6 сая төгрөгийн 3 ажлыг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан бол 50.0 сая төгрөгийн зураг төсвийн ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн, 20.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээний тендерт оролцогч ирээгүй зэргээс шалтгаалсан байна.

ОНХС-гийн хөрөнгийн гүйцэтгэлийг 802.6 сая төгрөгөөр дутуу олгосон нь гүйцэтгэгч байгууллагад олгох баталгаат хугацааны барьцаа 88.6 сая, он дамжин хэрэгжиж байгаа 4 төсөл арга хэмжээний 133.8 сая, хэрэгжээгүй 5 ажлын 141.4 сая, тендерийн хэмнэлт 68.7 сая, коронавируст цар тахлын улмаас комисс ажиллаагүй бичиг баримт дутуу зэрэг шалтгаанаар 370.1 сая төгрөгийг тус тус санхүүжүүлээгүйтэй холбоотой байна.

Хэрэгжээгүй нийт 141.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээний 3 төсөл арга хэмжээ хэрэгжих шатандаа байгаа бол 40.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжиж ирсэн бөгөөд газрын маргааны улмаас 35.0 сая, оршин суугчдын зөрчилтэй тулгарснаас 5.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй нь тооцоо судалгааг хангалтгүй хийснээс шалтгаалжээ.

В.2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийсэн байна.

Төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн нийт хөрөнгийн зардлын гүйцэтгэл 88.2 хувьтай гарч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 2 хувиар өссөн байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэлийг сумдаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №12

Хөрөнгийн зардлын гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Аймаг, сумдын нэр	2020 он		Зөрүү
	Төлөв	Гүйц	
Нийт хөрөнгийн зардал	12,175.5	10,742.7	1,432.8
Аймаг	9,542.5	8,583.0	959.5
Дархан сум	770.9	686.9	84.0
Хонгор сум	1,300.6	922.8	377.8
Шарын гол сум	334.5	330.5	4.0
Орхон сум	227.0	219.5	7.5

Хөрөнгийн зардалд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн төсөл арга хэмжээний зардлаас гадна Хонгор сумын ЗДТГ-ын 140.0 сая төгрөгийг төлөвлөжээ. Үүнээс Хонгор сумын ЗДТГ-т төлөвлөсөн хөрөнгийн зардлын гүйцэтгэл 13.4 хувьтай хэрэгжсэн нь

сумын орлогын эх үүсвэр дутсанаас шалтгаалжээ.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн 5 байгууллагад нийт 94.4 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдан авч хөрөнгө оруулалт хийснээс 47.5 сая төгрөгийн хөрөнгийг тухайн байгууллагын өмчлөлд шилжүүлсэн байна. Үүнд:

- Тагнуулын газарт 16.7 сая төгрөгийн автомашин,
- Мэргэжлийн хяналтын газарт 30.8 сая төгрөгийн авто машин

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” ойлгоно гэж заасантай нийцэхгүй байна.

Холбогдох байгууллагаас ирсэн санал:



МОНГОЛ УЛС
ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГА

45059 Дархан, Дархан-Уул аймаг
Утас: 7037-8023, Факс: 7037-7121,
И-мэйл: info@darkhan.gov.mn
Вэбсайт: www.darkhan.gov.mn

2021.04.19 № 1-10/229
танай _____-ны № _____-т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.ЧҮЛТЭМБАТ ТАНАА

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн
2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын төсөлтэй танилцаж хариу тайлбар, саналыг
гаргаж хүргүүлэв.

Хавсралт 23 хуудастай.

ДАРГА



Б.АЗЖАРГАЛ

4521100519

Хавсралт 2

Төрийн Аудитын газарт тайлбар хүргүүлэх тухай

2021 он					
№	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээний дугаар	Төсөвт өртөг	Тайлбар	Санал
1	Суудлын автомашин нийлүүлэх / Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт /	ОНТХО 2020-01/02	30.800.000.0 *	Монгол Улсын шадар сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020онд хамтран амжиллах ШС-20/007 гэрээний хэрэгжилт, Аймгийн Онцгой комиссын 2020 оны 12-р сарын хурлын шийдвэрээр	Хасуулах саналтай
2	Суудлын автомашин нийлүүлэх / Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба /	ОНТХО 2020-01/32	14.000.000.0	Хууль зүй дотоод хэргийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020онд хамтран амжиллах гэрээний хэрэгжилт, 2020.01.24,	Хасуулах саналтай
3	Суудлын автомашин нийлүүлэх / Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 445-р өнгө /	ОНТХО 2020-01/36	19.000.000.0	Хууль зүй дотоод хэргийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020онд хамтран амжиллах гэрээний хэрэгжилт, 2020.01.24, Таснуулын тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.1.4 дэх заалтын хэрэгжилт, Гэвт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 41.5 дэх заалтын хэрэгжилтийг ханган амжилтасан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 445-р өнгөд ашиглаж байгаа автомашин нь Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй бөгөөд тус байгууллагад гэрээгээр ашиглуулж байгаа болно.	Хасуулах саналтай
4	Суудлын автомашин нийлүүлэх / Аймгийн Таснуулын газрын албан хэрэгцээнд /	ОНТХО 2020-01/01	16.720.000.0 *	Хууль зүй дотоод хэргийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020онд хамтран амжиллах гэрээний хэрэгжилт, 2020.01.24, Таснуулын тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.1.4 дэх заалтын хэрэгжилт	Хасуулах саналтай
5	Техник төхөөрөмж нийлүүлэх (Полиметр, Термометр, Инсульт)	ОНТХО 2020-01/04	9.000.000.0	Монгол Улсын шадар сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020онд хамтран амжиллах ШС-20/007 гэрээний хэрэгжилт	Хасуулах саналтай

Хянасан ХОХБТХ-н дарга П.Батсүх

Тайлбар гаргасан аймгийн Ерөнхий адгийн засагч

Б.Батсүх

Тайланд тусгасан тэмдэглэл:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫГ
ТАЙЛАНД ТУСГАСАН ТЭМДЭГЛЭЛ

Холбогдох байгууллагын санал	Тайлбар
1. Монгол Улсын Шадар сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020 онд хамтран ажиллах ШС-20/007 гэрээний хэрэгжилт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын хурлын шийдвэртэй тул "Мэргэжлийн хяналтын газарт 30.8 сая төгрөгийн авто машин" гэснийг хасуулах саналтай.	1. Монгол Улсын Шадар сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний 3.11-д заасны дагуу хөрөнгө оруулалт хийсэн хэдий ч орон нутгийн өмчид бүртгэж тайлагнаагүй тул тайланд хэвээр үлдээв.
2. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт тул "Шүүхийн шинжилгээний албанд 14 сая төгрөгийн авто машин" гэснийг хасуулах саналтай.	2. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний 3.1.9.1-д заасны дагуу хөрөнгө оруулалт хийж, орон нутгийн өмчид бүртгэсэн тул тайлангаас хасав.
3. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, Тагнуулын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын хэрэгжилт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 41.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажилласан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорих 445 дугаар ангид ашиглаж байгаа автомашин нь Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй бөгөөд тус байгууллагад гэрээг ашиглуулж байгаа тул "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорих 445 дугаар нээлттэй хорих ангид 23.9 сая төгрөгийн авто машин" хасуулах саналтай.	3. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний 3.1.9.1-д заасны дагуу хөрөнгө оруулалт хийж, орон нутгийн өмчид бүртгэсэн тул тайлангаас хасав.
4. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, Тагнуулын тухай хуулийн 8.1. дүгээр зүйлийн 8.1.4 дэх заалтын хэрэгжилтийн дагуу "Тагнуулын газарт 16.7 сая төгрөгийн авто машин" гэснийг хасуулах саналтай.	4. Тагнуулын тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.4-т "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй" гэж заасны дагуу үүргээ биелүүлсэн боловч орон нутгийн өмчид бүртгэж тайлагнаагүй тул тайланд хэвээр үлдээв.
5. Монгол Улсын Шадар сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2020 онд хамтран ажиллах ШС-20/007 гэрээний хэрэгжилтийн дагуу "Стандарт, хэмжил зүйн хэлтэст 9.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж" гэснийг хасуулах саналтай.	5. Монгол Улсын Шадар сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний 3.24 дэх заалт, 2019 онд орон нутгийн төсвөөс 16.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь баримтаар нотлогдсон тул тайлангаас хасав.

АУДИТОР



У.БАТСҮРЭН

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Орлогын гүйцэтгэл нийт дүнгээр 108.6 хувиар биелсэн боловч Хонгор сумын төсвийн орлого 27.6 хувиар тасарснаас 213.5 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагуудад 94.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 47.5 сая төгрөгийн авто машиныг улсын төсвийн байгууллагын өмчлөлд шилжүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч Б.Азжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Б.Жаргалсайхан нарт зөвлөх нь:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар улсын төсвийн байгууллагуудад хийсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчлөлд шилжүүлж байх

Хонгор сумын Засаг дарга Т.Атархишигт зөвлөх нь:

- Сумын орлогыг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх, орлогыг нэр төрлөөр биелүүлж, өр төлбөр үүсгэхгүй ажиллахад анхаарах

Зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 11 дугаар сарын 30-ны дотор багтаан Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2021.04.20